



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар Б/Н

Баян-Овоо

Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, байгууллагын дотоод журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-т бэлтгэх ажлын хүрээнд байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтнаар бүжгийн багш Пүрэвдоржийн Энхсайхныг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилж, цаашид хавсран ажиллуулсугай.

2. (П. Энхсайхан)-д ажил хавсран гүйцэтгэсэн ажлын хөлсийг зохих журмын дагуу олгохыг нягтлан бодогч (Д. Даваадорж)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын албан бичиг хэргийг эмх цэгцтэй хөтөлж, архивын бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалж, хамгаалах, ирсэн явсан бичиг, хариутай бичгийн гүйцэтгэлд хяналт тавих, өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хөнгөн шуурхай чанартай гүйцэтгэж ажиллахыг (П. Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ш. ГАНГАНТУУЛ